



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

**“УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТР”-ЫН 2024 ОНЫ III УЛИРЛЫН
БАЙДЛААРХ САНХҮҮ, АЖ, АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

Аудитын дүгнэлт:

“Улсын драмын эрдмийн театр”-ын 2024 оны III улирлын байдлаарх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдал, түүний цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд төсвийн шууд захирагчийн **“Дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлт өгөв.

УЛААНБААТАР ХОТ
2024 он

Агуулга

ХҮСНЭЛТИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	1
1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО	2
3. ХАМРАХ ХҮРЭЭ, БҮРЭЛДЭХҮҮН ХУГАЦАА	2
4. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ	2
5.ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААР	3
6. ХУДАЛДАХ АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	7
7. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.	7
8. ДҮГНЭЛТ	9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын зөрчил, биелэлт.....	3
Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны эхний хагас жил/.....	4
Хүснэгт 3.Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны эхний хагас жил/.....	5
Хүснэгт 4. Үндсэн хөрөнгө.....	6
Хүснэгт 5. Бараа материал	6
Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд бүртгэсэн байна.	Error!
Bookmark not defined.	
Хүснэгт 7. Тэтгэмж олгох туслалцаа үзүүлэх тушаалуудыг буруу ангилсан.	Error! Bookmark not defined.
defined.	

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зоогийн газрын зураг	Error! Bookmark not defined.
-------------------------------------	------------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 7 дахь заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.6.2, 9.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5² дугаар зүйлийн 5².1, 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 5.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь гэсэн заалтуудыг үндэслэн хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

“Улсын драмын эрдмийн театр”-ын үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Соёлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актуудын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч шалгалтаар илэрсэн алдаа, дутагдлыг арилгах, засаж залруулахад оршино.

3. ХАМРАХ ХҮРЭЭ, БҮРЭЛДЭХҮҮН ХУГАЦАА

Тус шалгалтын удирдамж 2024 оны III улирал дуусаагүй байхад батлагдсан тул 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг, 1 дүгээр сараас 09 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаарх санхүүгийн анхан шатны баримтуудыг хамруулав.

Хяналт шалгалтыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Салбарын хяналтын газрын дарга Д. Ренчиндорж ахалж, Салбарын хяналтын газрын ахлах шинжээч, улсын ахлах байцаагч Д.Отгонбаяр, шинжээч, улсын ахлах байцаагч Б.Оюунзул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудитор Б.Лхагвасүрэн нар 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

4. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Байгууллагын регистрийн дугаар 9087028, үндсэн үйл ажиллагааны 100900034022, нэмэлт санхүүжилтийн 100900034422 тоот харилцах дансаар бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аудитын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг захирал Д.Цэрэнсамбуу, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Х.Цогзолмаа нар зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус театрын захирлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/58 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталжээ.

Тус театр нь 1963 онд Улсын драмын театрыг Улсын дуурь бүжгийн театраас салган Залуучуудын ордонд Ардын дуу, бүжгийн чуулгын хамт оруулжээ. Энэ цагаас эхлэн тус барилгыг “Драмын театрын барилга” гэх болсон байна.

Тус барилга нь 200 шахам өрөө тасалгаатай, 700-800 хүний суудалтай жүжгийн 2 танхим, 500 хүний багтаамж бүхий бүжгийн танхимтай.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 154 дүгээр тогтоолоор Драмын театрыг Д.Нацагдоржийн нэрэмжит болгосон ба 1981 онд “Улсын Драмын

академик театр”, 1994 онд “Үндэсний жүжгийн академик театр”, 2002 онд “Улсын драмын эрдмийн театр” хэмээн нэрлэжээ.

Тус театрын захирлын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Зохион байгуулалтын бүтэц, орон тоо ажилтнуудын сарын үндсэн цалинг батлах тухай” А/01 дүгээр тушаалаар:

- Захиргаа, удирдлагын хэлтэс /10/;
 - Маркетинг, төлөвлөлтийн алба /4/;
 - Байр, үйлчилгээний алба /10/;
- Уран бүтээлийн хэлтэс /3/;
 - Найруулагчид /4/;
 - Мэргэжлийн жүжигчний анги /1/;
- Үйлдвэр, техникийн хэлтэс /10/;
 - Гэрэл, дуу, шумны тасаг /5/;
 - Тайз, техникийн тасаг /3/; гэсэн 3 хэлтэс нийт 129 орон тоотойгоор баталсан байна.

5.ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Өмнө нь санхүүгийн, хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй болно.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй” гэсэн санал дүгнэлт өгчээ.

Дээрх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг дүгнэхэд 72.5 хувийн хэрэгжилтэй байна. /Хүснэгт 1-р үзүүлэв./

Хүснэгт 1. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын зөрчил, биелэлт.

/мянган төгрөг/

Гаргасан шийдэл	Товч утга	Нийт зөрчил		Биелэлтийн байдал, хувь
		Тоо	Дүн	
Зөвлөмж	Байгууллагын зардлыг түүвэрлэн шалгахад 7,530.6 мянган төгрөгийн хангамжийн материалыг бараа материалын дансанд орлого авч, шаардлагатай хэмжээгээр зарцуулалгүй, бараа үйлчилгээний зардалд шууд бүртгэсэн байна.	1	7,530.6	Бүрэн хэрэгжсэн, 100%
	Байгууллагын нягтлан бодогч нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхдөө тоог андуурч гүйлгээ хийснээс тайлант оны эцсээр Нийгмийн даатгалын хэлтэст 1,400.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.	1	1,400.9	Бүрэн хэрэгжсэн, 100%
	Тус байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг түүвэрлэн тоолоход дараах зөрчил илэрлээ. Үүнд: 1. Хөрөнгийн кодчилол байхгүйгээс ижил нэршилтэй хөрөнгийг тоолоход хүндрэлтэй, аль хөрөнгө гэдгийг нь тодорхойлох боломжгүй байна. 2. Ашиглах боломжгүй эвдэрсэн хөрөнгүүд байна. Тухайлбал: 5286-УНВ Хьюндай Старекс маркийн машин. 3. Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн нийт 889,761.9 мянган төгрөгийн хөрөнгүүд байна. Үүнээс ашиглах боломжгүйг нь актлан данс бүртгэлээс хасах, ашиглах боломжтой хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэх асуудлыг шийдвэрлээгүй байна.	1	-	Хэрэгжсэн, 90%
	Бараа материалын дэлгэрэнгүй болон товчоо тайлан, анхан шатны баримтуудыг Сангийн сайдын 100 дугаар тушаалд заасны дагуу бэлтгээгүй байна.	1	-	Хэрэгжиж байгаа, 50%

Нийт дүн	4	8,931.5	85
----------	---	---------	----

6. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны эхний хагас жил/

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,306,981.8	1,950,067.5	356,914.3	85%
УРСГАЛ ЗАРДАЛ	2,306,981.8	1,950,067.5	356,914.3	85%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,171,228.9	1,911,944.9	259,284.0	88%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,556,607.1	1,472,466.9	84,140.2	95%
Үндсэн цалин	867,590.4	903,536.1	(35,945.7)	104%
Нэмэгдэл	229,791.7	236,744.7	(6,953.0)	103%
Урамшуулал	138,140.2	49,657.2	88,483.0	36%
Унаа хоолны хөнгөлөлт	263,775.0	265,847.1	(2,072.1)	101%
Гэрээт ажлын хөлс	57,309.8	16,681.8	40,628.0	29%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,576.0	182,301.6	12,274.4	94%
Тэтгэврийн даатгал	132,311.5	124,942.8	7,368.7	94%
Тэтгэмжийн даатгал	15,566.1	14,874.8	691.3	96%
ҮОМШӨ-ний даатгал	7,783.2	9,614.5	(1,831.3)	124%
Ажилгүйдлийн даатгал	7,783.2	6,525.8	1,257.4	84%
Эрүүл мэндийн даатгал	31,132.0	26,343.7	4,788.3	85%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,671.6	77,666.7	10,004.9	89%
Гэрэл, цахилгаан, халаалт, ус	87,671.6	77,666.7	10,004.9	89%
Байрны түрээс	-	-	-	
Хангамж, бараа материалын зардал	1,984.1	1,879.9	104.2	95%
Бичиг хэрэг	600.0	525.0	75.0	88%
Тээвэр, шатахуун	-	-	-	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,384.1	1,354.9	29.2	98%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	-	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	-	
Нормативт зардал	668.1	-	668.1	0%
Эд хогшил, урсгал засварын зардал	129,508.2	74,648.3	54,860.0	58%
Томилолт, зочны зардал	-	-	-	
Дотоод албан томилолт	-	-	-	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,003.6	101,876.6	97,127.0	51%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	192,131.2	98,590.6	93,540.6	51%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500.0	-	2,500.0	0%
Тээврийн хэрэгслийн татвар	369.2	350.4	18.8	95%
Даатгалын үйлчилгээ	525.2	-	525.2	0%
Газрын төлбөр	3,478.0	2,578.8	899.2	74%
Бараа үйлчилгээний бусад зардал	1,210.2	1,104.9	105.3	91%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,752.9	38,122.6	97,630.3	28%
Бусад урсгал шилжүүлэг	48,565.6	-	48,565.6	0%

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	87,187.3	38,122.6	49,064.7	44%
---	----------	----------	----------	-----

Эх сурвалж: Санхүүгийн 2024 оны эхний хагас жилийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,950,067.5 мянган төгрөг буюу 85.0 хувьтайгаар зарцуулагдсан ба үндсэн цалин 104 хувь буюу 35,945.7 мянган төгрөгөөр, нэмэгдэл 103 хувь буюу 6,953.0 мянган төгрөгөөр, Унаа хоолны хөнгөлөлт 101 хувь буюу 2,072.1 мянган төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгал 124 хувь буюу 1,831.3 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Хүснэгт 3.Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны эхний хагас жил/
/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,792.1
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	193,792.1
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	187,667.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,667.1
2104	Хангамж, бараа материалын зардал	18,194.0
210401	Бичиг хэрэг	1,732.1
210402	Тээвэр, шатахуун	7,000.0
210403	Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	2,908.1
210406	БҮТЭЗҮЙЛС	6,553.8
2105	Нормативт зардал	6,750.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,750.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,276.0
210602	Тавилга	16,978.5
210604	Урсгал засвар	23,297.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,102.2
210801	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	96,102.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,344.9
210901	Төсвийн урамшуулал	23,844.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,125.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,125.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,125.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	222,359.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222,359.1
131104	Төсвийн дээд шатны захирагчаас олгосон санхүүжилт	32,000.0
131105	төсөвт байгууллагын өөрийн үйл.аж-ны хүрээнд бий болсон орлого	190,359.1
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	28,567.0

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар нийт 222,359.1 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого орсноос 18,194.0 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 6,750.0 мянган төгрөгийг нормативт зардалд, 40,276.0 мянган төгрөгийг Эд хогшил, урсгал засварын зардалд, 96,102.2 мянган төгрөгийг

бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 26,344.9 мянган төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд, нийт 193,792.1 мянган төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгө

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	7,281,224.2	-	-	7,281,224.2
Тээврийн хэрэгсэл	441,937.0	-	-	441,937.0
Тоног төхөөрөмж	877,698.9	11,599.0	168,204.1	721,093.8
Тавилга эд хогшил	218,610.7	30,292.9	6,689.6	242,214.0
Ном	-	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	11,143.6	-	-	11,143.6
Программ хангамж	2,800.0	-	-	2,800.0
Бусад биет бус хөрөнгө	438,274.0	-	-	438,274.0
Дүн	9,271,688.4	41,891.9	174,893.7	9,138,686.5

Эх сурвалж: Санхүүгийн 2024 оны эхний хагас жилийн тайлан

Тайлант хугацаанд 11,599.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 30,292.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу тус театрын захирлын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/15 дугаар тушаалаар 168,204.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,689.6 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж, 9,138,686.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Хүснэгт 5. Бараа материал

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	5,621.1	-	672.6	4,948.4
Бичиг хэргийн материал	850.0	15,556.1	15,556.1	850.0
Түлш шатах тослох материал	3,000.0	7,000.0	4,000.0	6,000.0
Бусад хангамжийн материал	1,343,719.3	157,406.1	228,212.1	1,272,913.3
Бэлэн бүтээгдэхүүн	17,847.4	-	-	17,847.4
Нийт дүн	1,371,037.7	179,962.2	248,440.8	1,302,559.1

Эх сурвалж: Санхүүгийн 2024 оны эхний хагас жилийн тайлан

Тайлант хугацаанд 179,962.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 248,440.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,302,559.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

6. ХУДАЛДАХ АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.

Хяналт шалгалтад хамрагдах хугацаанд тендер худалдан авалт хийгдээгүй байна.

7. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.

д/д	Мэдээллийн нэр төрөл	Талбарын тоо	Бодит байдал, илэрсэн зөрчил, анхаарах асуудал					
Төсөв ба гүйцэтгэл		46						
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	8	Мэдээлсэн.					
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт	8	Мэдээлсэн.					
3	Санхүүгийн тайлан	1	Хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлсэн боловч файл руу орж үзэх болохгүй.					
4	Хандив, тусламжийн орлого	1	Мэдээлсэн.					
5	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	Мэдээлсэн.					
6	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	Мэдээлсэн.					
7	Байгууллагын батлагдсан төсөв	1	Мэдээлсэн.					
8	Дараа жилийн төсвийн төсөл	1	2024 оны төсвийн төслийг мэдээлсэн.					
9	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	8	Мэдээлбэл зохих		Мэдээлсэн		Мэдээлээгүй	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
			51	613,363.9	38	401,945.5	13	211,418.3
10	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	8	Мэдээлбэл зохих		Мэдээлсэн		Мэдээлээгүй	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
			21	3,067,650.9	18	2,699,697.7	3	367,953.2
11	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	8	Мэдээлсэн.					
Хөрөнгө оруулалт худалдан авалт		27						
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	8	Мэдээлсэн.					
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1	Мэдээлсэн.					
3	Худалдан авах ажиллагааны тайлан	1	Хугацаа болоогүй					
4	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	1	Мэдээлсэн.					
5	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	8	Мэдээлсэн байна.					
6	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	8	Мэдээлсэн байна.					
Бусад		33						
1	Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл	8	Мэдээлсэн.					
2	Аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэн арга хэмжээний тайлан	1	Аудитын зөвлөмж, төлбөрийн актыг барагдуулсан талаар мэдээлэл оруулсан байна.					
3	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	8	Мэдээлсэн.					
4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд	8	Мэдээлсэн.					

	орсон өөрчлөлт							
5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	8	Мэдээлсэн.					
6	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	8	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн		Огт мэдээлээгүй		
			тоо	дүн	тоо	тоо	дүн	тоо
			30	846,423.1	8	498,334.8	22	355,898.4
			төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 30 тушаал шийдвэр мэдээлэхээс 22 тушаалыг огт мэдээлээгүй, 5 тушаалыг хугацаа хоцроож мэдээлсэн байна.					
Нийт дүн		106						

Долоо.Цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж ажиллах.
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн дотоод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ын “5.Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар байрлах тохиолдолд өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг улсын төсөвт тусгаснаар тооцно”, “6. Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар ашиглалтын зардлаар байрлаж болно. Энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулахгүй (ашиглалтын гэрээ)” гэсэн заалтуудтай мөрдөж гэрээ байгуулж ажиллах.
3. Эд хөрөнгийн тооллогын комиссын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тушаалаар батлахдаа санхүүгийн албан хаагч нарыг оруулахгүй байх.
4. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Маягт, заавар батлах тухай” 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”-ын дагуу албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХМаягт БМ-10 маягтаар хөтлөх.
5. Эд хөрөнгийн тооллого хийж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах.
6. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.1. “Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны

болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана.” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

7. Захиргаа, удирдлагын хэлтсийн албан тушаалтнууд архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамрагдах.

8. ДҮГНЭЛТ

“Улсын драмын эрдмийн театр”-ын 2024 оны III улирлын байдлаарх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдал, түүний цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд төсвийн шууд захирагчийн **“Дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлт өгч байна.

Илэрсэн алдаа дутагдалыг залруулах, тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яаманд албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

СОЁЛЫН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---